

Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 27 сарын 14-дрийн 05 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт

СҮХБААТАР АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хөгжлийн төлөвлөлтийн болон ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөний баримт бичигт тусгагдсан зорилт	Хэрэгжүүлэх хугацаа	Гарах үр дүн			Зарцуулах хоронгийн хэмжээ /аял.төг/	Эх үүсвэр	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага
				Шалгуур үзүүлэлт /хэмжих нэгж/	Суурь үзүүлэлт	Хугацааны эцэст			
1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ /Хуудас 62-210/									
1.1. Эрчимжсэн болон уламжлалт мал аж ахуйн газрын ерөнхий бүсчлэл тогтоох чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ /Хуудас 130-139/									
1	Газар тариалангийн бүсийн хил заагийг газар дээр нь баталгаажуулж, мэдээллийн санд бүртгэх, бүсэд газар ашиглах горим, дэглэмийг тогтоож мөрдүүлэх	Алсын хараа-2050-8.3.5. Газрын тухай хуулийн 52.4. Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан нутаг дэвсгэртээ бэлчээрийн болон суурин мал маллагааны бүс нутгийг тогтоож болно.	2023-2027	Талбайн хэмжээ, га	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр ерөнхий байршил тогтоогдсон.	110.4 мянган га газар тариалангийн бүсийн хил зааг газар дээрээ тогтоогдож, горим дэглэмтэй болж, газар тариалангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байна.	105,0	ОНТ	Аймгийн Засаг дарга, ЗДТГ ХХААГ ГХБХБГ
			2027-2037	1 бүсийн горим дэглэм, түүний хэрэгжилт		Бүсийн горим дэглэмийг мөрдөгдсөн байна. /шаардлагатай тохиолдолд нэмэлт тодотгол хийнэ. Горим дэглэмийн хэрэгжилтэд жил бүр үнэлгээ хийдэг болсон байна/.	Үйл ажиллагаагаар	-	
2	Эрчимжсэн мал аж ахуйн бүсийн хил заагийг газар дээр нь баталгаажуулж, мэдээллийн санд бүртгэх, бүсэд газар ашиглах горим, дэглэмийг тогтоож мөрдүүлэх		2023-2027	Талбайн хэмжээ, га	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр ерөнхий байршил тогтоогдсон.	21.8 мянган га ЭМАА-н бүсийн хил зааг газар дээрээ тогтоогдож, горим дэглэмтэй болж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх нөхцөл бүрдсэн байна.	45,0	ОНТ	Аймаг, сумын Засаг дарга, ГХБХБГ ХХААГ
			2027-2037	1 бүсийн горим дэглэм, түүний хэрэгжилт		Бүсийн горим дэглэмийг мөрдөгдсөн байна. /шаардлагатай тохиолдолд нэмэлт тодотгол хийнэ. Горим дэглэмийн хэрэгжилтэд жил бүр үнэлгээ хийдэг болсон байна/.	Үйл ажиллагаагаар	-	
3	Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн бүсэд байгаа зөвшөөрөгдөхгүй бүсэд газар ашиглалтыг судлах, нийцүүлэх ажлыг зохион байгуулах		2023-2027	Бүсийн горим дэглэм хангагдсан бүсийн талбайн хэмжээ, га	Тариалангийн тухай хуулийн 24-р зүйлд тусгасан боловч хэрэгждэггүй. Уламжлалт МАА-тай зөрчилтэй байсаар байна. Энэ нь Сүхбаатар аймарт харьцангуй бага боловч тариалангийн галбай нэмэгдэх хэрээр зөрчил үүсэж болзошгүй.	Сүхбаатар, Мөнххаан, Түмэнцогт, Эрдэнэцагаан сум эхний ээлжинд хийгдэж газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй болон уламжлалт мал аж ахуй хоорондын зөрчил маргаан байхгүй болно.	Үйл ажиллагааны зардлаар+судалгаагаар		Сумын Засаг дарга, ГХБХБГ ХХААГ
			2026-2032			Асгат, Халзан, Уулбаян, Дарьганга сум			
			2033-2037			Наран, Онгон сум			

4	Хот орчмын эрчимжсэн мал аж ахуйн бэлчээрийн бүсийн хил заагийг газар дээр нь баталгаажуулж, мэдээллийн санд бүртгэх, бүсэд газар ашиглах горим, дэглэмийг тогтоож мөрдүүлэх		2023-2027	Талбайн хэмжээ, га	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр ерөнхий байршил тогтоогдсон. Энэ бүсэд холимог ашиглалтууд явагдахаар байна.	Төлөвлөсөн 176.0 мянган га бүсийн хил зааг газар дээрээ тодорхой болж, хот орчмын эрчимжсэн болон хагас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх нөхцөл бүрдсэн байна. Нийт 176.0 мянган га газар нутгийг даацад тохируулан ашигладаг болно.	50.0	ОНТ	Аймаг, сумын Засаг дарга, ГХБХБГ ХХААГ
			2027-2037	1 бүсийн горим дэглэм, түүний хэрэгжилт		Бүсийн горим дэглэмийг мөрдүүлэх /шаардлагатай тохиолдолд нэмэлт тодотгол хийнэ. Горим дэглэмийн хэрэгжилтэд жил	Үйл ажиллагаагаар	-	
5	Шинээр эргэлтэд оруулах тариалангийн газраас эрчимжсэн мал аж ахуйд тэжээлийн ургамал тариалах талбай, хадлангийн талбайг тэргүүн ээлжид хуваарилах		2023-2027	Талбайн хэмжээ, га	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд туссан байна	Эхний ээлжид 5 мянган га-д судалгаа хийж, газар хуваарилах нарийвчилсан зураг төсөлтэй болж, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж эхэлсэн байна.	120.0	ОНТ	Аймгийн Засаг дарга, ГХБХБГ ХХААГ
			2028-2032			10 мянган га-д судалгаа, зураг төслийн дагуу хэрэгжинэ.			
			2033-2037			10 мянган га-д судалгаа, зураг төслийн дагуу хэрэгжинэ.			
6	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүсэд гүний усны эх үүсвэрийн хайгуул судалгаа хийх		2023-2027	Талбайн хэмжээ, га	Усны хайгуул судалгаа байхгүй	Эхний ээлжид Сүхбаатар, Мөнххаан, Түмэнцогт, Эрдэнэцагаан сумын 100 мянган га газарт судалгаа хийж эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүсэд нэн шаардлагатай усны эх үүсвэрийг тодорхойлж, ашиглалтын зураг төсөл боловсруулагдана.	500.0	УТ	Аймгийн Засаг дарга, ЗДТГ ХХААГ
			2028-2032			Хөрөнгө оруулалтын төслийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэнэ.			
			2033-2037			Асгат, Халзан, Уулбаян, Дарьганга 70 мянган га газарт Наран, Онгон 30 мянган га газарт			
7	Хот орчмын эрчимжсэн мал аж ахуйн бүсэд мал бүхий иргэдэд газар олгох байршлыг тогтоож батлах, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж газар олголт хийх Лавигдах шаардлага: Бэлчээрийн даац багтаамж, талхагдлын зэргээс хамаарч малын тоог хязгаарлана. Өндөр ашиг шимт мал маллахыг дэмжинэ. Уламжлалт аргаар бэлчээр ашиглах бол 1 өрх 150 хонь толгойгоос дээшгүй тооны малтай байхыг зөвшөөрөх ба сум бүрийн онцлог, бэлчээрийн нөөцөөс хамааран өөр өөр тогтоож болно.		2023-2027	Талбайн хэмжээ, га	Нарийвчилсан зураг төсөл байхгүй, тухайн жилийн төлөвлөгөөнд хэрэгцээгээр тусгаж хэрэгжүүлдэг.	Эхний ээлжид Сүхбаатар, Мөнххаан, Түмэнцогт, Эрдэнэцагаан суманд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх боломжтой зураг төсөлтэй болсон байна.	Үйл ажиллагааны зардлаар+зураг төсөл боловсруулах зардал 260.0		Аймаг, сумын Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ
			2028-2032			Зураг төслийг цахим системд байршуулж иргэд сонголт хийх боломжийг хангаж, газар олгох үйл ажиллагаа нээлттэй ил тод болгоно.			
			2033-2037			Асгат, Халзан, Уулбаян, Дарьганга сум Наран, Онгон сум			

1.2. Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээ Хуудас 139-195/

1.2.1. Бэлчээрийн газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа /Хуудас 164-171/

1	"Аймгийн бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах үлгэрчилсэн журам"-ыг боловсруулан баталгаажуулах	"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.20., 6.2.12., 8.3.3., 3.3.5., Газрын тухай хуулийн 20.2., 20.2.1., 20.2.2., Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.1.10., 35.1.13., 35.1.14	2023-2027	Аймгийн хэмжээнд мөрдөгдөх нэгтгэсэн 1 журам /тус тусдаа журам байх эсэхийг батлах эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ/ Хэрэгжилтийг хангах, хяналт хийх, дүгнэлт хийх эрх бүхий 1 ажлын хэсэг	Зохицуулсан эрх зүйн баримт бичиг байхгүй. Бусад аймаг сумдад батлагдан хэрэгжиж байгаа туршлага байна.	Аймгийн хэмжээнд бэлчээрийн газар ашиглахтай холбогдсон нийтлэг үлгэрчилсэн эрх зүйн баримт бичигтэй болно. Үүнд: - Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх - Бэлчээрийн эрсдэлийн сан бий болгох; - Бэлчээрийн доройтлыг бууруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх; - Бэлчээрийг хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлж буй газарт харуул тавих, харуулын зардлын хэмжээг төлөвлөх, эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлэх, ашиглах; - Бэлчээрийн газарт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хариуцлага тооцох, бэлчээрт учруулсан хохирлыг тооцох - Бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглах, хамгаалах; - Бэлчээр нутагт уст цэг гаргах, ашиглах харилцааг зохицуулах, хамтарсан хөрөнгө оруулалт хийх; - Нугын болон нугархаг бэлчээр, нуур тойром орчмын бэлчээрийг ашиглах; - Сум дундын отрын бүсийг ашиглах; - Цагаан зээр, бусад зэрлэг амьтдын амьдрах чухал орчин дахь уст цэгийг ашиглах.	Үйл ажиллагааны зардлаар	Аймгийн Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ
			2028-2032	Журмын хэрэгжилтийн үнэлгээ /3 жил тутамд 1 удаа сайжруулалт хийх тухай ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмж/				
			2033-2037					
2	"Сумын бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам"-ыг боловсруулан баталгаажуулах		2023-2027	Сумын онцлогт нийцсэн 1 журам /тус тусдаа журам байх эсэхийг батлах эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ/ Хэрэгжилтийг хангах, хяналт тавих, дүгнэлт хийх эрх бүхий 1 ажлын хэсэг	Зохицуулсан эрх зүйн баримт бичиг байхгүй, бусад аймаг сумдад батлагдан хэрэгжиж байгаа туршлага байна.	Сумын хэмжээнд бэлчээрийн газрын харилцаатай холбоотой дараах чиглэлээр эрх зүйн харилцаатай болно. Үүнд: - Бэлчээр нутгийг зохион байгуулалттайгаар улирлын хуваарь, сэлгээтэйгээр ашиглах сум багийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөө - Уламжлалт мал аж ахуй эрхлэх бүсийн; - Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүсийн; - Тусгай хамгаалалттай газар нутагт бэлчээр ашиглах; /хамгаалалтын захиргаагаар хамтран боловсруулах шаардлагатай/ - Сум, багийн отрын нөөц нутгийн	Үйл ажиллагааны зардлаар	Сумын Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ
			2028-2032	Журмын хэрэгжилтийн үнэлгээ /3 жил тутамд 1 удаа сайжруулалт хийх тухай ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмж/				
			2033-2037					

3	Бэлчээр ашиглалтын хариуцлагын гэрээний загварыг боловсруулан батлуулах, бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах		2023-2027	1 гэрээний загвар	Одоогоор тусгайлсан батлагдсан гэрээний загвар байхгүй.	Сум, орон нутгийн онцлогт тохирсон ландшафтын 10 дэд район, байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн 3 муж, 5-н тойргийн онцлогийг харгалзсан бэлчээр ашиглалтын гэрээтэй болсон байна. Гэрээний хэрэгжилтийг хангах, хяналт тавих эрх бүхий ажлын хэсэг байгуулагдаж байнгын ажиллагаатай болсон байна.	Үйл ажиллагааны зардлаар		Аймгийн Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ
			2028-2032						
			2033-2037						
1.2.2. Бэлчээрийг сайжруулах, нөхөн сэргээх бэлчээрийн менежментийн арга хэмжээ /Хуудас 139-171/									
1	Төлөвлөж буй зун намрын, өвөл-хаврын улирлын бэлчээрийн улирлын хуваарийг батлах, хуваарь сэлгээгүй ашиглалтыг зогсоох /хуудас 140-143/		2023-2027	Талбайн хэмжээ, га	Өвөл-Хаврын бэлчээр нийт нутаг дэвсгэрийн 58%, Зун-Намрын бэлчээр 39.3%-ийг тус тус эзэлж байна. Хуваарь сэлгээгүй ашиглаж буй бэлчээр сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгдэх хандлагатай болсон.	Төлөвлөсөн зун намрын 3234.6 мянган га бэлчээр, өвөл-хаврын улирлын бэлчээр 4774.4 мянган га бэлчээр ашиглалтын ерөнхий хуваарь сумын НДХТ-р батлагдаж бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байна. Хуваарь сэлгээгүй ашигласан тохиолдолд хариуцлага тооцох механизм бий болсон байна.	Үйл ажиллагааны зардлаар		Сумын Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ
			2028-2032						
			2033-2037						
2	Бэлчээрийг ашиглалтаас түр чөлөөлөх, өнжөөхөөр төлөвлөсөн бэлчээрийг үе шаттайгаар өнжөөх. /хуудас 142-143/	"Алсын хараа-2050" монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.6.9., 6.2.9., Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6.2.8., Газрын тухай хуулийн 52.1., 52.2.,	2023-2027	Талбайн хэмжээ, га	Өнжөөх шаардлагатай бэлчээрийн талбай 1144.6 мянган га байна.	Өнжөөхөөр төлөвлөсөн 286,0 мянган га газарт бэлчээрийн менежментийг олон нийтийн оролцоотой төлөвлөн, хэрэгжүүлнэ. Бэлчээрийн төлөв байдал, чанарыг бэлчээрийн мониторингийн баталгаажуулсан байна. 429,0 мянган га газарт	Үйл ажиллагааны зардлаар		Сумын Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ
			2028-2032						
			2033-2037						
3	Бэлчээрийн нөхөн сэргэлт, төлөв байдал, чанарыг хянах мониторингийн сүлжээг ажиллуулах, бэлчээрийн мэдээллийн системийг бий болгох		2023-2027	Мониторингийн цэгийн тоо	Бэлчээрийн газрын фото мониторингийн 383 цэгүүд дээр жил бүр 8 дугаар сарын дундаар хэмжилт хийдэг.	383 фото мониторингийн цэгийг 430 болгож нэмэгдүүлнэ. 430 фото мониторингийн цэгийг 500 болгож нэмэгдүүлэх 500 фото мониторингийн цэгийг 600 болгож нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны зардлаар /төсвийг төлөвлөлттэй уялдуулан нэмэгдүүлэх/		ГХБХБГ Сумын газрын даамал
			2028-2032						
			2033-2037						
4	Байнгын ашиглалттай бэлчээрийг хуваарьтай ашиглаж богино хугацаагаар сэлгэх замгаар ачааллыг бууруулж, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх /хуудас 140/		2023-2027	Талбайн хэмжээ, га	Хуваарь сэлгээгүй ашиглаж буй 221.3 мянган га бэлчээр байна.	Сэлгээгүй ашигладаг доройтсон бэлчээр үгүй болсон байна. Бэлчээрийн төлөв байдал сайжирч, ачаалал буурсан байна.	Үйл ажиллагааны зардлаар		Сумын Засаг дарга, ГХБХБГ ХХААГ
			2028-2032						
			2033-2037						
5	Бэлчээрийн фото мониторингийн ажлын үр дүнг сум багийн түвшинд танилцуулан, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний үр дүнг жил бүр дүгнэх, шаардлагатай тохиолдолд нэмэлт тодотгол хийж байх /Хуудас 145-162/	"Алсын хараа-2050" хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.6.9., 6.2.9.,	2023-2027	Жил бүр 1 дүгнэлт, хэрэгжилтийн үнэлгээ	Бэлчээрийн фото мониторингийн ажил жил бүр хийж байгаа боловч түүний үр дүнд үндэслэн бэлчээрийн төлөв байдал,	Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийн судалгааг жил бүр хийж, дараа жил хийгдэх арга хэмжээний зөвлөмжийг холбогдох сумын Засаг дарга нарт хүргүүлж, хэрэгжүүлнэ. Бэлчээрийн	Үйл ажиллагааны зардлаар		Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ
			2028-2032						
			2033-2037						

		МУ-ын 3Г-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6.2.8., Газрын тухай хуулийн 52.1., 52.2.,			чанарыг сайжруулах ажлууд хийгдэхгүй байна.	менежментийн төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж баталж, хэрэгжүүлдэг болсон байна.			
1.2.3. Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудыг чадавжуулах арга хэмжээ /Хуудас 164-171/									
1	Бэлчээр ашиглалтын хэсгүүдийн эрх ашгийг хамгаалах, мал аж ахуйн үйлдвэрлэл, борлуулалтын талаар төрийн байгууллагатай харьцах эрх үүрэг бүхий "Сумын бэлчээр ашиглагчдын холбоо"-г байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг үнэлэх	"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 6.1.1., 8.3.12., 8.3.13.	2023-2027	Байгуулагдсан холбооны тоо	13 сумд бэлчээр ашиглагчдын холбоо байхгүй байна.	13 сум тус бүр бэлчээр ашиглагчдын холбоотой болсон байх. Төрийн байгууллага болон бэлчээр ашиглагчдын хоорондын зохицуулалтыг хийх систем бүрдэнэ. Сумдын бэлчээр ашиглалтын хэсгүүдийн үйл ажиллагаа идэвхэжнэ. Төрийн байгууллагатай харилцах хамтын ажиллагаа сайжирна. Нэгдсэн зохион байгуулалтад орж бэлчээрийн менежментийг хэрэгжүүлдэг, санхүүжүүлдэг механизм бий болно.	Үйл ажиллагааны зардлаар		Сумын Засаг дарга, ЗДТГ ХХААГ
			2028-2032	Холбооны чадавхын үнэлгээ		Холбоо нь малчдыг төлөөлөх, эрх ашгийг хамгаалах чадамж, бааз суурьтай болсон байх			
			2033-2037	Зохион байгуулсан арга хэмжээний тоо		Малчдаа идэвхжүүлэх, сургах, зохион байгуулалтад оруулах, бэлчээрээ хамгаалах арга хэмжээг нэгдэж хэрэгжүүлдэг болсон байх.			
2	Багийн төвүүдийг "Малчдын хөгжил, мэдээллийн төв" болгон тохижуулах, сургалтын техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, менежментийн дэмжлэг үзүүлэх		2023-2027	Хөгжүүлэлт хийгдсэн багийн тоо	13 сум 67 багтай. Үүнээс 21 нь суурин газрын баг байна. Хөдөөгийн ихэнх багийн төвүүд хурал зохион байгуулах төдийгөөр ашиглагдаж байна.	13 сумын хөдөөгийн 13 багийн төвийг тохижуулах, үйлдвэрлэл эрхлэх төв болсон байх Багийн төвүүд олон талт үйл ажиллагаатай болж цаашдаа үйлдвэрлэлийн төв болон хөгжих боломж бүрдэнэ. Малчид хоршиж хөдөлмөрлөх хандлага төлөвшинэ	920.0	УТ+ ОНТ	Сум, багийн Засаг дарга, ХХААГ
			2028-2032			13 сумын хөдөөгийн 16 багт			
			2033-2037			13 сумын хөдөөгийн 17 багт			
3	Малчдыг идэвхжүүлэх, чадавжуулах, зах зээлийн зарчмаар эрсдэл багатай, бэлчээрийн даацад тохируулан мал аж ахуй эрхлэх арга барил, чиг хандлагад сургах		2023-2027	Хамрагдсан өржийн тоо, Мэдээлэл авсан өрхийн тоо	2021 оны статистик мэдээгээр 8570 малчин өрх байна.	Жил бүр 50 өрх сургалтад хамрагдаж байх.	160.0	ОНТ	Засаг дарга, ЗДТГ ХХААГ
			2028-2032		Бэлчээр хамгаалах талаар малчдын идэвх хандлага сул байна.	Бэлчээр хамгаалал, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудын идэвх сайжирсан байна.			
			2033-2037		Зохион байгуулалтад орж чаддаггүй.	Сургалтаас гарсан үр дүнг бусад малчдад үзүүлсэн нөлөөллийн үнэлгээгээр дүгнэнэ. Үнэлгээг сум багаар хийж байх			

4	Залуу малчид, мал бүхий иргэдийн дунд уламжлалт мал маллагааны сайн туршлагыг таниулах, малчдын залгамж халааг бэлтгэх, чадавхжуулах чиглэлд эрдэмтэн судлаачид, сайн туршлага бүхий хашир тэргүүний малчидтай туршлага солилцох уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах, мэдээлэл түгээх	2023-2027 2028-2032 2033-2037	Хамрагдсан залуу малчдын тоо	Статистик мэдээгээр 15435 малчин байгаагаас 4998 нь 16-34 насны малчид байна. Нийт малчдын 41.9 % нь эмэгтэй малчид байна. Бэлчээр хамгаалах талаар залуу малчдыг идэвхжүүлэх шаардлагатай.	Жил бүр 50-с доошгүй залуу малчинд сургалт хийнэ. Бэлчээр хамгаалал, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд уламжлалт бэлчээр ашиглалтын сайн туршлагуудыг нэвтрүүлж, бэлчээр ашиглалт, хамгаалал сайжирна. Бэлчээр хамгаалах малчдын идэвх санаачилга нэмэгдэнэ. Үр дүнг нэвтрүүлсэн, жишиг болсон бэлчээр ашиглалтын сайн туршлагаар дүгнэнэ. Сум баг бүрээр үнэлнэ.	160.0	ОНТ	Сум, багийн Засаг дарга, ЗДТГ ХХААГ
5	Бэлчээрийн менежментийг үе шаттай хэрэгжүүлэх замаар бэлчээрийн доройтлыг зогсоох, бэлчээрийг даац, багтаамжид тохируулан ашиглах, бүс нутгийн онцлогтой уялдуулан бэлчээр ашиглалт, хамгаалалт, сайжруулалт, нөхөн сэргээлтийн талаарх малчид, мэргэжилтний мэдлэг чадварыг дээшлүүлэх	2023-2027 2028-2032 2033-2037	Хамрагдсан малчид, мэргэжилтний тоо	2021 оны статистик мэдээгээр 15435 малчин байна. Малчдад ШУ-ны үндэслэлтэй бэлчээрийн менежмент хийх талаар зөвлөн туслах үйлчилгээ хүртээмжгүй, ойлголтыг бүрэн өгч чадахгүй байна.	Жилд 1-с доошгүй удаа иргэд малчдыг сургах идэвхжүүлэх талаар зөвлөгөө, сургалт зохион байгуулах мэргэжилтнүүдийн үр чадварыг үнэлнэ. Бэлчээр хамгаалал, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт тавих систем бий болно. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт сайжирна.	160.0	ОНТ	Сум, багийн Засаг дарга, ЗДТГ ХХААГ
6	Мал эмнэлэг, мал үржлийн тасгийн үйл ажиллагааг сайжруулах, сүргийн эргэлтийг зохион байгуулах мэргэжлийн зөвлөх үйлчилгээний нэгжийг сум бүрд байгуулах	2023-2027 2028-2032 2033-2037	Байгуулсан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх нэгжийн тоо	Мал эмнэлэг үржлийн тасгийн үйл ажиллагаа хүртээмжгүй байна. Мэргэжлийн зөвлөх үйлчилгээг өрхийн түвшинд хүрч үзүүлэх боломжгүй байна.	3 суманд мал зүйчийн мэргэжлийн зөвлөх байгууллага, нэгж байгуулсан байна. Иргэд малчдад сүргийн эргэлтээ хийж, зохистой бүтэц бий болгох, ашиг шимийг нэмэгдүүлэх талаарх мэргэжлийн зөвлөх үйлчилгээний нэгж бий болж өрх бүрд хүрэх боломжтой болно. 5 суманд мал зүйчийн мэргэжлийн зөвлөх байгууллага, нэгж байгуулсан байх. Үлдсэн 5 суманд байгуулсан байх.	Үйл ажиллагааны зардлаар /мэргэжлийн зөвлөх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй ААНБ/		Засаг дарга, ЗДТГ ХХААГ
1.2.4. Сүргийн эргэлтийг зөв зохион байгуулах замаар бэлчээрийн ачааллыг бууруулах арга хэмжээ /Хуудас 164-171/								
1	Малын тооны өсөлтөөс хамаарах эрсдэлийг бууруулж, нэгжийн ашиг шим, чанарыг дээшлүүлэх, зохистой сүргийн бүтцийг бий болгож, малын чанарыг сайжруулах замаар малын тоо толгойг жил бүр 3-6% бууруулах сүргийн эргэлтийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх /даацад тохируулах/	2023-2027 2028-2032 2033-2037	Ашиг шим нь дээшилсэн малын сүргийн бүтцэд эзлэх %, Даац ашиглалтын %, Сүргийн эргэлтийн төлөвлөгөөний биелэлтийн %	Хонин толгойгоор тооцсон оор нийт сүргийн 34 % нь адуу, 26 % нь хонь, 24 % нь үхэр, 15 % нь ямаа, 1 % нь тэмээ байна. Таван төрлийн малын үржлийн ажлын стратегийг суманд хэрэгжүүлэх төлөвлөгөө байхгүй байна.	Жил бүр малын тоог 3-6%-р буулгаж бэлчээрийн даацад тохируулна. Сумын түвшинд үржлийн ажлын стратеги төлөвлөгөөтэй болж МАА-ын бодлого төлөвлөлт хэрэгжих боломж бүрдэнэ. Бэлчээрийг даац, чадавхад тохируулан ашигладаг болно. Таван төрлийн малын үржлийн ажлын стратегийг суманд хэрэгжүүлсэн байдалд үнэлгээ хийнэ.	260.0		Сумын Засаг дарга, ЗДТГ ХХААГ

2	Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжийг сумдад байгуулан чадавхжуулж, хээлтүүлэгчийг малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжид бүрэн төвлөрүүлж, чанар хангамжийг сайжруулж, мэргэжлийн зөвлөх үйлчилгээг малчны хотонд хүргэх, малын генетик нөөцийн ашиглалтыг сайжруулах	ажиллагааны хөтөлбөр 3.3.8.,	2023-2027	Байгуулсан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх нэгжийн тоо Үйлчлүүлсэн малчин өрхийн тоо	Мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээг малчид авч чадахгүй тул өөрсдийн дураар үржлийн ажлыг төлөвлөж байгаа нь малын эшиг шимд нөлөөлж байна	3 суманд мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжийг байгуулсан байх. Малын генетик нөөцийн ашиглалтыг сайжруулах замаар тооноос чанарт шилжих бодлогыг хэрэгжүүлэх, малчдын орлого буурахгүйгээр бэлчээрийн ачааллыг бууруулах боломж нэмэгдэнэ. 5 суманд сал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжийг байгуулсан байх. Үлдсэн 5 суманд суманд байгуулсан байх.	Үйл ажиллагааны зардлаар /мэргэжлийн зөвлөх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй ААНБ/		Сумын Засаг дарга, ЗДТГ ХХААГ	
3	Үржлийн цөм сүргийн аж ахуйг байгуулах, хээлтүүлэгч болон цөм сүргийг мэргэжлийн байгууллагын хяналтад авах		2023-2027	Байгуулсан цөм сүргийн аж ахуйн тоо Малчдад нийлүүлсэн өндөр ашиг шимт үржлийн малын тоо	Сум бүрд Цэвэр үлдрийн үхэр 43439, адуу 658, Хонь 681639, ямаа 603526 байна.	3 суманд үржлийн цөм сүргийн аж ахуйтай болсон байх. Малчдын орлогыг бууруулахгүйгээр малын тоог бууруулах боломж нэмэгдэнэ. Сүргийн эргэлтийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг болно. 4 суманд үржлийн цөм сүргийн аж ахуйтай болсон байх. 5 суманд үржлийн цөм сүргийн аж ахуйтай болсон байх.	Үйл ажиллагааны зардлаар /Иргэн, ААНБ гэрээгээр/		Сумын Засаг дарга, ЗДТГ ХХААГ	
			2028-2032							
			2033-2037							
4	Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги 2020-2030-ын дагуу сум, багийн түвшинд үржлийн ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх		2023-2027	Малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөөтэй болсон сум, багийн тоо, Хэрэгжилтийн үнэлгээ	13 сум, 67 багтай. Үүнээс 21 нь суурин газрын баг байна. Сум, багийн түвшинд үржлийн ажлын стратеги төлөвлөгөө байхгүй	13 сум, хөдөөгийн 46 баг үржлийн ажлын төлөвлөгөө, сүргийн эргэлтийн төлөвлөгөөтэй болж хэрэгжүүлж эхэлсэн байх. Үржлийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, малын ашиг шимийг сайжруулах ажлууд хийгдэнэ. шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөг засаж сайжруулах ажлыг хийх	260.0		Засаг дарга, ЗДТГ ХХААГ	
			2028-2032							
			2033-2037							
1.2.5. Малын ашиг шимийг дээшлүүлэх, түүхий эдийн гарц, чанарыг сайжруулах замаар бэлчээрийн ачааллыг бууруулах арга хэмжээ /Хуудас 164-171/										
1	Мал, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах нөхцөлийг бүрдүүлэх, түүхий эд, бүтээгдэхүүнийг стандартын дагуу бэлтгэн нийлүүлэх тогтолцоог хөгжүүлж, ХАА-н биржийн үйл ажиллагааг бий болгох	"Алсын хараа-2050" монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 8.3.18. Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2023-2027	Байгуулсан нэгжийн тоо, ХАА-ын биржийн үйл ажиллагааны үнэлгээ	Аймгийн хэмжээнд ХАА-н боловсруулах үйлдвэрлэлийн салбар муу хөгжсөн. ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийг тогтолцоог сайжруулж, боловсруулах үйлдвэрлэлийг	Сум бүрд 1-2 түүхий эд бэлтгэх аж ахуй нэгжийг бий болгосон байх. Түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах, түүхий эд бүтээгдэхүүнийг стандартын дагуу бэлтгэн нийлүүлэх тогтолцоо бий болж ХАА-ын биржийн үйл ажиллагаа идэвхэжсэн байна. Зах зээлийн багтаамж, хэрэгцээгээр түүхий эд бэлтгэх аж ахуй нэгжийг нэмэгдүүлнэ Түүхий эд бэлтгэлийг 100% стандартын дагуу хийдэг болсон байх.	Үйл ажиллагааны зардлаар /Иргэн, ААНБ гэрээгээр/		Засаг дарга, ЗДТГ ХХААГ	
2028-2032										
2033-2037										

2	Түүхий эд, бүтээгдэхүүнд чанараас хамаарсан эдийн засгийн хөшүүрэг бий болгох замаар малчдын ашиг орлогыг дээшлүүлэн малын тоог бууруулж бэлчээрийн ачааллыг бууруулах /Түүхий эд, бүтээгдэхүүний чанараас хамаарсан үнийн ялгавартай систем тогтоох, эдийн засгийн хөшүүрэг бий болгох/	3.3.4, 3.3.11.	2023-2027	Ажлын хэсгийн дүгнэлт, хэрэгжилтийн үнэлгээ	хөгжүүлэх нь зөвхөн эдийн засгийн ач холбогдлоос гадна малын тоог бууруулан бэлчээрийг даац чадавхад тохируулан ашиглахад эерэг нөлөө үзүүлнэ. Түүхий эдийн чанар, мөшгөлтийн тогтолцоог хөгжүүлж тооноос чанарт шилжих бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.	Түүхий эдийн чанар, хяналт, мөшгөлтийн тогтолцоо бүрэн нэвтэрсэн байх. Малын тоонд ач холбогдол өгөхөөс илүү түүхий эд бүтээгдэхүүний чанарт илүүтэй анхаардаг болно. Малчдын орлогыг бууруулахгүйгээр малын тоог 3-6%-р буулгах төлөвлөгөө хэрэгжиж үр дүнгээ өгч эхэлсэн байх.	Үйл ажиллагааны зардлаар		Засаг дарга, ЗДТГ ХХААГ	
			2028-2032							
			2033-2037							
3	Өсвөр малын биологийн чадавхыг ашиглаж эр малын сүрэгт эзлэх хувийн жинг бууруулах, дэвшилтэт технологиор хөнгөлж маханд нийлүүлэх аргыг нэвтрүүлэх замаар мах бэлтгэлийг явуулж бэлчээрийн ачааллыг бууруулах		2023-2027	Эр малын сүрэгт эзлэх хувийн бууралт, % Дэвшилтэт технологиор хөнгөлж зах зээлд нийлүүлсэн эр малын эзлэх %		Зах зээлд нийлүүлсэн бүтээгдэхүүний 50-с доошгүй хувь нь дэвшилтэт технологиор хөнгөлсөн малын мах байх. Бэлчээрийн ачаалал багасна. Чанарлаг өсвөр малын мах, түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт нэмэгдэнэ. Зах зээлд нийлүүлсэн бүтээгдэхүүн 100% дэвшилтэт технологиор хөнгөлсөн малын мах байх.	Үйл ажиллагааны зардлаар /мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй ААНБ, иргэн/		Засаг дарга, ЗДТГ ХХААГ	
			2028-2032							
			2033-2037							
1.2.6. Бэлчээр тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /Хуудас 143-171/										
1	Ашиглалт багатай, алслагдсан бэлчээрийн усан хангамжийг сайжруулах замаар эрчимтэй ашиглалттай бэлчээрийн ачааллыг бууруулах зорилгоор гүний усны нөөцтэй газрыг эхний ээлжид усжуулах /Хуудас 143-145/	"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.9., 8.3.4., Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 3.3.4.	2023-2027	Усжуулагдсан бэлчээрийн талбайн хэмжээ, га Гаргасан уст цэгийн тоо	Усжуулах 1411649 га бэлчээрийг гидрогеологийн зураглалтай давхцуулан үзэхэд 39.4% нь Газрын доорх локал, хязгаарлагдмал нөөц бүхий усгай чулуулаг бүхий газар, 11.79% нь Локал тархалттай ундарга ихтэй эсвэл их тархалттай устай чулуулаг бүхий газарт байна.	Гидрогеологийн нөхцөлөөр боломжтой 300 мянган га бэлчээрийг усжуулна. Ашиглалт багатай бэлчээрийг зохистой ашиглаж бусад бэлчээр нутгийн ачааллыг бууруулах боломжийг бүрдүүлнэ. Усан хангамжгүйн улмаас ашигладаггүй бэлчээр байхгүй болсон байна. Худаг уст цэг гаргах боломжгүй газрыг өвлийн отрын нөөц бэлчээр болгоно.	Урьдчилсан хайгуул судалгаа – 240 сая + Худаг уст цэг гаргах зардал	УТ+ ОНТ+Мал чид	Сумын Засаг дарга, ЗДТГ ХХААГ	
			2028-2032			Гидрогеологийн нөхцөлөөр боломжтой 422.3 мянган га бэлчээрийг усжуулах.				
			2033-2037			Гидрогеологийн нөхцөл муутай үлдсэн 689.3 мянган га-д судалгаа хийх				
2	Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх арга хэмжээг 440.5 мянган га газарт тэргүүн ээлжид хэрэгжүүлэх. /Хуудас 163-164/		2023-2027	Хэрэгжүүлсэн талбайн хэмжээ, га	2023 судалгаагаар 1009.0 мянган га талбайд үлийн цагаан оготно тархсанаас хортон мэрэгчтэй тэмцэх шаардлагатай 440.5 мянган га газар байна. Хортон мэрэгчтэй тэмцэх хуваарь төлөвлөгөө байдаггүй.	200 мянган га бэлчээрт хортон мэрэгчтэй тэмцэх ажил хийсэн байх. Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх хуваарь төлөвлөгөөтэй болсон байх. 240.5 мянган га бэлчээрт хортон мэрэгчтэй тэмцэх ажил хийсэн байх. Бусад бэлчээр нутагт дахин судалгаа хийж хортон мэрэгчтэй тэмцэх ажил хийх газрын байршлыг дахин тогтооно.	Үйл ажиллагааны зардлаар+төлөвлөгөөгөөр тогтоосон ажлын хэмжээгээр төсөвт тусгах		Засаг дарга, ЗДТГ ХХААГ	
		2028-2032								
		2033-2037								

3	Тэжээлийн нэг ба олон наст ургамал, сэлгээнд буурцагтан тариалах, тэжээл боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх		2023-2027	Зах зээлд нийлүүлсэн бүтээгдэхүүний хэмжээ, тн	1987 оны судалгаагаар тогтоосон газруудаас 47521 га нь агро үйлдвэрлэлийн 1-р группийнх, 75233 га нь агро үйлдвэрлэлийн 2-р группийнх, 17387 га нь агро үйлдвэрлэлийн 3-р группийнх байсан. Тэжээлийн аж ахуйд тохиромжтой талбайн нөөц их байна.	Тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг 1 дахин нэмэгдүүлсэн байх. Тэжээл үйлдвэрлэлийн бааз суурь сайжирч ялангуяа өвөл, хаврын улиралд бэлчээрт үзүүлэх дарамт буурна.	Үйл ажиллагааны зардлаар		Аймаг, сумын Засаг дарга, ЗДТГ ХХААГ	
2028-2032	Тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг 1 дахин нэмэгдүүлсэн байх.	Хэрэгцээгээр нэмэгдүүлэх.								
2033-2037										
4	Хадаж болох бэлчээрийн судалгааг хийх, бусад газар ашиглалтаас чөлөөлөх арга хэмжээг зохион байгуулах		2023-2027	Талбайн хэмжээ, га	Тогтвортой ургацтай газруудад жил бүр судалгаа хийх, ашиглалтын горим тогтоох шаардлагатай	Өмнөх судалгаагаар тогтоогдсон 332800 га хадаж болох бэлчээрт жил бүр судалгаа хийсэн байна.	Судалгааны зардал 60.0+Үйл ажиллагааны зардал		Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ	
2028-2032	Тогтвортой ургацтай газруудад ашиглалтын горим тогтоож хадланд бүртгэнэ.									
2033-2037										
1.3. Биологийн төрөл зүйлийн амьдрах чухал орчин, нүүдлийн зам газартай давхцаж буй бэлчээр ашиглалтыг зохицуулах газар/зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ /Хуудас 171-179/										
1	Зэрлэг амьтны амьдрах орчны судалгааг хийсэн мэдээлэлд үндэслэн бэлчээрийн давхцал нутгийн хил заагийг газар дээр нь тогтоох, бэлчээр ашиглах горим, дэглэмийг батлах /улирал бүрээр/	“Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.1.2.	2023-2027	Горим дэглэм тогтоосон газрын хэмжээ, га	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тархац тусгагдсан.	Ховор амьтдын тархац нутаг 831.8 мянган га, Цагаан зээрийн амьдрах чухал орчин бүхий газар 2.2 сая га газарт хэрэгжүүлнэ. Зэрлэг амьтны бэлчээр нутгийг ашиглах хамгаалах горим дэглэм тогтоох бүс нутаг тодорхой болсон байна.	20.0+Үйл ажиллагааны зардал		Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ БОАЖГ	
2028-2032	Горим дэглэмийг мөрдүүлэх, бэлчээр ашиглалтын хариуцлагын журмыг хэрэгжүүлэх									
2033-2037	Горим дэглэмийг мөрдүүлэх, бэлчээр ашиглалтын хариуцлагын журмыг хэрэгжүүлэх									
2	Зэрлэг амьтны бэлчээрлэх нутгийг ашиглах, хамгаалах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө, бэлчээрийн менежментийн нэгдсэн төлөвлөгөөг сум бүр боловсруулж батлуулах		2023-2027	Төлөвлөгөө батлагдан хэрэгжиж буй сумын тоо, Ажлын хэсгийн дүгнэлт	Зэрлэг амьтны бэлчээрлэх нутгийг хамгаалах эрх зүйн баримт бичиг байхгүй зарим бэлчээр нутгийг сэлгээгүй ашиглаж байна.	Ховор амьтдын тархац нутаг 831.8 мянган га, Цагаан зээрийн амьдрах чухал орчин бүхий газар 2.2 сая га газарт газар ашиглах хуваарь батлагдаж хэрэгжиж эхэлсэн байх. Зэрлэг амьтны бэлчээрлэх нутагт үзүүлэх дарамт буурсан байна.	80.0+Үйл ажиллагааны зардал		Сумын Засаг дарга, ЗДТГ БОАЖГ ХХААГ ГХБХБГ	
2028-2032	Зэрлэг амьтны бэлчээрлэх нутагтай давхцал бүхий бэлчээр ашиглах төлөвлөгөөг хэрэгжүүлнэ, шаардлагатай тохиолдолд нэмэлт тодотгол хийнэ.									
2033-2037										

3	Цагаан зээрийн төллөдөг газрыг хамгаалах, бэлчээр ашиглалтаас 6-р сарын 10-аас 7-р сарын 10-ны хооронд бүрэн чөлөөлөх арга хэмжээг зохион байгуулах. Бусад цаг хугацаанд гал түймрийн эрсдэлээс сэргийлэх зайлшгүй шаардлагын үүднээс бэлчээрээр ашиглах хуваарь, хадлан бэлтгэх төлөвлөгөөг БОАЖГ, ХХААГ-тай хамтран боловсруулж, хэрэгжүүлэх	2023-2027	Талбайн хэмжээ, га 1 баримт бичиг	Цагаан зээрийн төллөх үе ихэвчлэн 6-р сарын 10-аас 7-р сарын 10-ны хооронд байдаг. Цагаан зээрийн төллөдөг газрыг зохистой ашиглах тусгайлсан төлөвлөгөө байдаггүй	Цагаан төллөдөг газрыг 6-р сарын 10-аас 7-р сарын 10-ны хооронд бүрэн чөлөөлдөг болсон байх. /Бэлчээр, хадлангаар ашиглах хуваарь сэлгээний төлөвлөгөө батлагдаж хэрэгжиж эхэлсэн байна./ Цагаан зээрийн төллөдөг газар нутгийг хамгаалах, зохистой ашиглах боломж бүрдэнэ. Бэлчээр, хадлангаар ашиглах хуваарь сэлгээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийнэ.	Үйл ажиллагааны зардлаар		Сумын Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ БОАЖГ
		2028-2032						
		2033-2037						
4	Ховор амьтан, ургамлын тархац нутаг биологийн төрөл зүйлийн амьдрах чухал орчин бүхий газар, түүний орчмын нөлөөллийн бүсэд нутагладаг малчидтай байгуулах бэлчээр ашиглалтын гэрээнд хамгаалах үүргийг тусгайлан тусгаж өгөх, гэрээний биелэлтийг жил бүр үнэлж хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж байх	2023-2027	Нөлөөллийн бүс дэх малчин өрхтэй байгуулсан гэрээний тоо, хамрагдалтын хувь Гэрээний биелэлтийн жил бүрийн үнэлгээ	Ховор зэрлэг амьтан, ургамлын тархац нутаг, биологийн төрөл зүйлийн амьдрах чухал орчин бүхий газрын баталгаажсан хил зааг байдаггүй байхгүй. Энэ нь уламжлалт бэлчээр ашиглагчдын малын тоог хязгаарлах зэргээр үүрэг хүлээлгэх боломжгүй болгож байна.	Биологийн төрөл зүйлийн амьдрах чухал орчин бүхий газар түүний орчмын нөлөөллийн бүсэд нутагладаг бүх малчдыг бүрэн хамруулсан байх. Гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх ажлуудыг жил бүр хийнэ. Ховор зэрлэг амьтан, ургамлын тархац нутаг, биологийн төрөл зүйлийн амьдрах чухал орчин бүхий газар нутгийг зохистой ашиглах, хамгаалах механизм бий болно. Гэрээний хэрэгжилтийг дүгнэх, шаардлагатай тохиолдолд гэрээг сайжруулна. Үр дүнгээр хариуцлага тооцох арга хэмжээ авах ажлууд тогтмол хийдэг болсон байна.	Үйл ажиллагааны зардлаар		Сумын асаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ БОАЖГ
		2028-2032						
		2033-2037						
5	Шувуудын өндөглөдөг газар, амьдрах чухал орчин бүхий газрыг нарийвчлан судалж, горим дэглэм тогтоох шаардлагатай газруудад мал маллах хугацаа, хамгаалах үүргийг бэлчээр ашиглалтын гэрээнд тусгах	2023-2027	Тогтоосон талбайн хэмжээ, га Нөлөөллийн бүс дэх малчин өрхтэй байгуулсан гэрээний тоо, хамрагдалтын хувь Гэрээний биелэлтийн жил бүрийн үнэлгээ	Шувууд өндөглөдөг хамгаалалтад авах шаардлагатай газрын судалгаа хийх шаардлагатай Цөөн тооны шувууд байдаг тойром бүрд бүхий бага талбайг хамарсан газруудыг нарийвчлан судлаагүй.	Шувуудын өндөглөдөг газар, амьдрах чухал орчин бүхий газар дахь бүх малчдыг хамруулсан байх. Шувуудын өндөглөдөг газруудыг нэмж судлан бүртгэнэ. Шувуудын өндөглөдөг газар, амьдрах чухал орчин бүхий газрыг зохистой ашиглах механизм бүрдэнэ. Гэрээний хэрэгжилтийг дүгнэх, шаардлагатай тохиолдолд гэрээг сайжруулна. Үр дүнгээр хариуцлага тооцох арга хэмжээ авах ажлууд тогтмол хийдэг болсон байна.	Үйл ажиллагааны зардлаар		Сумын Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ БОАЖГ
		2028-2032						
		2033-2037						
6	Зэрлэг амьтан /тарвага/ шинээр нутагшуулахаар төлөвлөсөн газрыг хамгаалах, бэлчээр ашиглалтаас түр чөлөөлөх	2023-2027	Талбайн хэмжээ, га	Тарвага шинээр нутагшуулахаар төлөвлөсөн 72082 га газар байгаа бөгөөд тэдгээр газарт хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхойгүй.	72082 га газрыг чөлөөлж тарвага нутагшуулах ажлыг хийсэн байна. Биологийн төрөл зүйлийг дахин нутагшуулах арга хэмжээ үр дүнтэй хэрэгжинэ. Өмнөх үе шатанд хийгдсэн ажлын үр дүнг үнэлэх, газар ашиглалтаас чөлөөлөх арга хэмжээг үргэлжлүүлэх шаардлагатай эсэхийг шийдвэрлэнэ.	Үйл ажиллагааны зардлаар		Сум, багийн Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ БОАЖГ
		2028-2032						
		2033-2037						

7	Цагаан зээр, бусад зэрлэг амьтдын чухал амьдрах орчин бүхий газар, нүүдлийн зам газраар отор нүүдэл хийх, дамжин өнгөрөх газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх		2023-2027	Бэлчээрийн төлөв байдлаас хамааруулан жил бүр шинэчлэн тогтоосон баримт бичиг, ажлын хэсгийн дүгнэлт	Судлаачдын зураглалын газруудыг баталгаажуулах шаардлагатай. Цагаан зээр, бусад зэрлэг амьтдын амьдрах чухал орчин бүхий газарт отор нүүдэл хийж олон тооны мал оруулан талхалж доройтолд оруулсан тохиолдлууд байна.	Цагаан зээр, бусад зэрлэг амьтдын амьдрах чухал орчин 2.2 сая га бэлчээр болон холбоос нутаг хамгаалагдаж зайлшгүй тохиолдолд отор нүүдэл хийх бол зохицуулагдсан байх. Отор нүүдэл хийх газрыг жил бүр судалгаанд үндэслэн тогтоодог болсон байх. Үр дүн хэрэгжилтийг жил бүр дүгнэдэг болсон байх	Үйл ажиллагааны зардлаар	Сумын Засаг дарга, ЗДТГ ХХААГ БОАЖГ
1.4. Хадлангийн газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээ /Хуудас 180-185/								
1.4.1. Хадлангийн газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хүрээнд хуулийг хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах /Хуудас 180-185/								
1	Байгалийн хадлангийн газрыг иргэн, аж ахуйн нэгж, хот айл, малчдын бүлэг, малчдад эзэмшүүлэх, гэрчилгээ олгоход гэрээнд тусгах нөхцөлийг тогтоох, хэрэгжилтэд хяналт тавих	Газрын тухай хуулийн 20.1.1.	2023-2027 2028-2032 2033-2037	Батлагдсан баримт бичиг, хэрэгжилтийн үнэлгээ	Аймгийн нутаг дэвсгэрийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн хадлангийн газрыг хуваарилах зохистой ашиглах эрх зүйн зохицуулалт байхгүй	Хадлангийн газрыг хуваарилах зарчим тодорхой болж, эзэмшүүлэх ажиллагаа нээлттэй ил тод болсон байна. Гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлыг жил бүр хийж байх, шаардлагатай тохиолдолд мониторинг хийж, гэрээг сайжруулах	Үйл ажиллагааны зардлаар	Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ
2	Бусад ангиллын газраас болон биологийн төрөл зүйлийн амьдрах чухал орчин, төлөдөг газарт хадлан бэлтгэх асуудлыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх		2023-2027 2028-2037	Батлагдсан баримт бичиг Судалгаагаар тогтоож, бүртгэсэн талбайн хэмжээ, га		Жил бүр судалгаа хийх, сэлгээний схемтэй болсон байна. Биологийн төрөл зүйлийн амьдрах чухал орчин, төлөдөг газраас хадлан авах асуудал, хуваарь тодорхой болно. Тогтвортой ургацтай газруудыг хадланд бүртгэх эсэх асуудлыг судалж шийдвэрлэх. Газар ашиглалтын төлөвлөгөө боловсруулах	Үйл ажиллагааны зардлаар	Сумын болон багийн Засаг дарга, ЗДТГ ХХААГ БОАЖГ
1.4.2. Хадлангийн газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах хүрээнд /Хуудас 180-185/								
1	Хадлангийн газрын байршил, хил заагийг газар дээр нь нарийвчлан тогтоож, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг Газрын тухай хуульд заасан хугацаанд тогтмол хийх, газрын нэгдмэл сангийн бүртгэлд бүртгэлжүүлэх	Газрын тухай хуулийн 53.1., 53.2., 53.3.,	2023-2027 2028-2032 2033-2037	Бүртгэгдсэн талбайн хэмжээ, га Төлөвлөгөөт ГТБЧХБ-ны дүгнэлт	Төлөвлөсөн 104142 га газар байна. 1980 оны судалгааны материалд хадлан 69100 га хадаж болох бэлчээр 332800 га газар бүртгэгдсэн байгаагаас ихэнх нь талхлагдан доройтож хадлан авахаа байсан байна. Хуучин тогтоогдсон хадлангийн газрууд ихэнх нь бэлчээрээр ашиглагдаж байгаагаас гадна бүр	104.1 мянган га хадлан бүртгэгдсэн байна. Хяналт мониторингийг жил бүр хийдэг болсон байна. Хадлангийн газрын төлөв байдал, чанарын мониторингийг жил бүр хийх, 5 жил тутамд ГТБЧХБ хийх	70.0	Сумын Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ
2	Төлөвлөсөн 104.1 мянган га хадлангийн газрын 10-с доошгүй хувийг аймгийн тусгай хэрэгцээнд авах, ашиглалтын горим дэглэмийг тогтоох, мал бэлчээхийг хориглох	Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 3.3.7.	2023-2027 2028-2032 2033-2037	Талбайн хэмжээ, га		10.4 мянган га хадлангийн газар аймгийн тэжээлийн сангийн хадлангийн газарт бүртгэгдэж, аймгийн тэжээлийн нөөцийг бүрдүүлэх боломжтой болсон байна. Хэрэгцээгээр нэмж авах эсэх асуудлыг судалгаагаар тогтооно.	Үйл ажиллагааны зардлаар	Аймгийн Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ

3	Хадлангийн газраар бүртгэгдсэн газруудыг хуулийн дагуу хадлан авах хүртэл мал бэлчээхийг хориглох	2023-2027 2028-2032 2033-2037	Хуулиар тогтоосон горим дэглэмийн хэрэгжсэн талбайн хэмжээ, га	хуваарь сэлгээгүй ашиглагдаж байна.	Хадлангийн газарт мал бэлчээх явдал бүрэн зогссон байна.Хадлангийн газар хамгаалагдаж, төлөв байдал, чанар сайжирна. Мал бэлчихээс хамгаалах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны зардлаар		Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ
4	Хадлангийн газрын үр ашгийг нэмэгдүүлэх, хамгаалах, сэлгэх арга хэмжээг боловсруулах ГЗБ-ын төсөл боловсруулж, хэрэгжүүлэх	2023-2027 2028-2032 2033-2037	Төлөвлөгөө хийгдсэн талбайн хэмжээ, га Хэрэгжилтийн үнэлгээ		104.1 мянган га хадлангийн газарт төлөвлөгөө хийгдсэн байх Хадлангийн газрыг зүй зохистой ашиглах, төлөв байдлыг сайжруулах арга хэмжээ тодорхой болно. Хадлангийн газрын төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, нэмэлт тодотголыг хийх	100.0	УТ+ОНТ	Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ
5	Хадлан, хадаж болох бэлчээрийн төлөв байдал, чанарыг хянах, жил бүрийн мониторингийг хийх, судалгааны мэдээллийг бүртгэх, цахим сан байгуулах	2023-2027 2028-2032 2033-2037	Мониторинг судалгаа хийгдсэн талбайн хэмжээ, га		Судалгаагаар тогтоосон 104142 га газарт, өмнөх судалгаагаар тогтоосон хадлан 69100 га, хадаж болох бэлчээр 332800 га газарт жил бүр мониторинг хийх. Хадлангийн газрын төлөв байдлыг хянах, хариуцлагын тогтолцоо сайжирсан байна. Мониторингийн мэдээллийн сангийн баяжилтыг хийх, ГЗБ-ын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах эсэх зөвлөмжийг боловсруулах	50.0		Сумын Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ
1.4.3. Хадлангийн газрын нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд /Хуудас 180-185/								
1	Төлөв байдал нь доройтсоны улмаас хадланд ашиглахаа байсан газруудыг хамгаалах, төлөв байдлыг сайжруулж эргүүлэн ашиглах	2023-2027 2028-2032 2033-2037	Төлөв байдал сайжирч хадланд бүртгэгдсэн талбайн хэмжээ, га	Өмнөх судалгаагаар тогтоосон хадлан 69100 га хадаж болох бэлчээр 332800 га газар байна.	Доройтолд өртсөн 72.3 мянган га хадлангийн газрын төлөв байдлыг сайжруулах арга хэмжээ хэрэгжиж хадлангийн газрын нөөц нэмэгдэнэ. Хадлангийн газар ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны зардлаар		Сумын Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ
2	Төлөв байдлыг сайжруулах, хамгаалах хадлангийн газруудад хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, өөрийн хүч хөрөнгөөр сайжруулсан тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж болох газрын байршлыг тогтоох, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх	2023-2027 2028-2032 2033-2037	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр төлөв байдлыг нь сайжруулсан талбайн хэмжээ, га	Өмнөх судалгаагаар хадлан 69100 га, хадаж болох бэлчээр 332800 га тогтоогдсон газар байна.	72.3 мянган га хадлангийн газрын төлөв байдлыг сайжруулж 30%-ийг иргэн, ААН байгууллагад ашиглуулна. Доройтолд өртсөн хадлангийн газарт оруулах иргэн, ААНБ хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. Хадлан тэжээлийн нөөц хангамж сайжирна. Хадлангийн газар ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Үлдсэн хадлангийн газрыг иргэн ААН байгууллагад ашиглуулах эсэх асуудлыг тухайн жилийн ГЗБ-ын төлөвлөгөөнд тусгаж шийдвэрлэнэ.	Үйл ажиллагааны зардлаар		Сумын Засаг дарга, ЗДТГ ГХБХБГ ХХААГ

1.5. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай бусад газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээ /Хуудас 185-190/									
